



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар Д/495

Хэрлэн сум

Өсвөр насны хүүхдүүд болон  
эцэг эхчүүдэд зориулсан цуврал лекцэд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 18 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.9.1 дэх заалт, хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд цуврал лекцийн дөрөвдүгээр ээлжийг зохион байгуулах зардалд 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 09 дугаар сарын 26-ны  
дугаар захирамжийн хавсралт

Төсвийн тооцоо

Д/д	Зардлын нэр төрөл	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сургагч багшийн хөлс	цаг	4	1,500,000	6,000,000
<b>Нийт</b>					<b>6,000,000</b>